



ЗАВХАН АЙМАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/
01

Улиастай

┌ Ур чадварын нэмэгдэл олгох тухай ┐

Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 50.1, Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 14-ны өдрийн 96 дугаар тогтоол, Улсын бүртгэлийн ерөнхий газрын орон нутаг дахь бүртгэлийн байгууллагын дүрмийн 3.3.10, “Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 7.31 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Тус хэлтсийн 2017 оны хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэн ажилласан албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг хавсралтад дурдсан хэмжээгээр олгосугай.

2.Албан хаагчдад олгох ур чадварын нэмэгдлийг Хэлтсийн төсвийн холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б. Мөнхсүлд/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.СҮХБААТАР



ЗАВХАН АЙМАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/02

Улиастай

Комисс томилох тухай

Оюуны Өмч, Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2018 оны Б/65 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Отгон сумын Улсын бүртгэгч Цээсүрэнгийн Лхагвасүрэнгийн, албан үүрэгт томилогдож байгаа Мандахын Жамбалсүрэн нарын ажлыг хүлээлцэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: И.Батсайхан-Улсын ахлах бүртгэгч

Гишүүд: Б.Мөнхсүлд-Ахлах нягтлан бодогч

С.Норов-Улсын бүртгэгч

2. Ажлыг холбогдох хууль, журмын дагуу хүлээлцэж, ажил хүлээлцсэн тэмдэглэлийг 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр хэлтсийн даргад танилцуулахыг комиссын дарга Улсын ахлах бүртгэгч / И.Батсайхан /-д үүрэг болгосугай.

ДАРГА



9130454 8116129103

Ж.СҮХБААТАР



ЗАВХАН АЙМАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 4/03

Улиастай

Ээлжийн амралтын хуваарь батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, Оюуны Өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журмын 7.23 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хэлтсийн албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг нэгдүгээр, Сумдын Улсын бүртгэгчдийн ээлжийн амралтын хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Албан хаагчдын ээлжийн амралтын олговоргыг ээлжийн амралт олгох тухай “Мэдэгдэл”-ийг үндэслэн тооцон олгож байхыг Ахлах нягтлан бодогч /Б.Мөнхсүлд/-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Иргэний бүртгэлийн Улсын бүртгэгч /Н.Энхбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.СҮХБААТАР

000 006



ЗАВХАН АЙМАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/04

Улиастай

Комисс томилох тухай

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын орон нутаг дахь бүртгэлийн байгууллагын дүрмийн 4.2, 4.4-ийг үндэслэн **ТУШААХ НЬ:**

1. Нярав, Бичиг хэргийн ажилтан Ч.Баасанжав, П.Очир-Эрдэнэ нарын ажлыг хүлээлцэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Б.Бат-Эрдэнэ – Бүртгэл хяналтын Улсын байцаагч

Гишүүд: Б.Мөнхсүлд – Ахлах нягтлан бодогч

С.Хоролгарав – Улсын бүртгэгч

2. Ажлыг холбогдох хууль, журмын дагуу хүлээлцэж, ажил хүлээлцсэн тэмдэглэлийг 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Хэлтсийн даргад танилцуулахыг комиссын дарга Бүртгэлийн хяналтын Улсын байцаагч /Б.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.СҮХБААТАР

